

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТНЫ МАНЛАЙЛАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE LEADERSHIP OF THE EMERGENCY MANAGEMENT OFFICE

Э.Ууганбаяр

Удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага, стратегийн тэнхимийн
дэд профессор, дэд хурандаа

E.Uuganbayar

Associate Professor, Lieutenant Colonel, Emergency Management and
Strategy Professor Team, Academy of Management, University of Internal affairs of
Mongolia

Хураангуй: Онцгой байдлын алба нь удирдах албан тушаалтны манлайлал, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх шинэ арга барилыг эрэлхийлж, удирдах албан тушаалтны манлайллын ур чадварт дүн шинжилгээ хийх замаар удирдах албан тушаалтны манлайллыг дээшлүүлэх арга замыг тодорхойлж энэхүү илтгэлээр илэрхийлэхийг зорьсон.

Abstract: *The Emergency Management Service aims to improve the leadership, professionalism, ethics, and discipline of senior officials, seek new ways to lead disaster relief operations, and identify ways to improve senior officials' leadership by analyzing senior officials' leadership skills and expressing this in this report.*

Түлхүүр үг: Онцгой байдлын алба, манлайлал, удирдлагын түвшин, стратеги түвшний удирдлага, оператив түвшний удирдлага, тактикийн түвшний удирдлага.

Key words: *Emergency services, leadership, management level, strategic level management, operational level management, tactical level management.*

Удиртгал

Манлайллын тухай ойлголтыг шинжлэх ухааны үндэслэл болон практик чиглэл бүхий олон тодорхойлолттой. АНУ-ын манлайлал судлаач, Жеймс Мак Бернс 1978 онд манлайллын талаар 130 тодорхойлолт байгааг,¹ Бернард М Басс,

¹ Burns, J.Me.,. Leadership., New-Work.,. 1978

Роналд.Е.Рижжо нар 1990 онд манлайллын талаар 1500 гаруй тодорхойлолт байгааг тоочсоныг судлаачид судалгааны ажилдаа дурдсан байдаг.¹

Тэгвэл монгол хэлний үйл үгийн аймаг буюу үйл хөдлөл, биеэр гүйцэтгэх үйлдэл талаасаа "манлайлах" гэдэг нь: дагуулах, удирдах, чиглүүлэх, өмнө нь явах гэсэн үйл үгээр тайлбарлагдана.

Leadership буюу манлайлал гэх ухагдахуун нийтийн хэрэглээнд XX зуунаас эхлэн нэвтэрсэн бол leader буюу манлайлагч гэх үг харьцангуй эрт бий болсон. Гарал, үүслийн хувьд эртний англи хэлний lithan, laedan буюу урагшлах, зам заах, газарчлах, to lead буюу чиглүүлэн удирдах, жолоодох гэсэн утгатай.

Удирдлагын аливаа нөлөөлөл нь байгууллагын зорилгыг биелүүлэх эрх ашигт үйлчилдэг. Иймд байгууллагын зорилгыг биелүүлэхийн тулд удирдах ажилтны зүгээс бусад хүмүүст нөлөөлөх чадварыг манлайлал гэж тодорхойлно.

Удирдах албан тушаалтны манлайлал

Удирдах албан тушаалтны манлайллыг авч үзэхийн өмнө нэр томъёоны ойлголтыг мэдэх нь чухал бөгөөд "Удирдах буюу удирдлага" гэдэг ойлголтыг шинжлэх ухааны талаас нь ойлгох нь чухал юм. Аливаа үзэгдэл юмсын тогтолцооны төлөв байдлыг нөгөөд шилжүүлэх буюу үзэгдлийн хөгжил, хөдөлгөөнийг залж чиглүүлдэг хүчин зүйлийг илэрхийлэхийн тулд удирдлага гэдэг ойлголтыг хэрэглэдэг.

Монгол хэлний их тайлбар толь бичигт "Удирдлага гэдэг үг нь удирдах үйл ажиллагаа, удирдах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэгч, удирдамж буюу заавар өгөх"² гэсэн утгыг агуулсан байна.

“Удирдлага гэдэг бол системийг нарийн цэгцтэй байлгах, өөрөөр хэлбэл түүний тухайн орчинд үйлчлэх объектив зүй тогтолд тохируулж байх явдал гэж ерөнхий байдлаар нь тодорхойлж болно”³ эрдэмтэн Новик. И.Б гэж тодорхойлжээ.

Удирдлага бол байгууллагын зорилтуудыг томъёолж түүнд хүрэхийн тулд зайлшгүй төлөвлөх, зохион байгуулах, идэвхжүүлэх, хянах үйл явц юм. Зохион байгуулалт болон удирдлагын салбарын тэргүүний онолч Питер Ф. Друкер удирдлагыг дараах байдлаар тодорхойлжээ.

Удирдлага гэдэг нь зохион байгуулалтгүй, бөөгнөрсөн хүмүүсийг үр ашигтай, бүтээмжтэй бүлэг болгон өөрчлөх үйл ажиллагааны онцгой хэлбэр бөгөөд энэ онолоор Онцгой байдлын албаны төлөвлөлтийн гол цөм нь хэд хэдэн ойлголтоор илэрч байна. Үүнд:

¹ Бернард М Басс., Роналд.Е.Рижжо., Манлайллын гарын авлага., 1990.

² Монгол хэлний их тайлбар толь бичиг. УБ., 2015.

³ В.Удвал “Удирдлагын эрх зүй. УБ., 2000. 38 дахь тал

Удирдахуй гэдэг нь “байгууллага, түүний гишүүдийн өмнөх зорилтыг биелүүлэхийн тулд хүмүүстэй ажиллаж, хүмүүсийн тусламжтайгаар ажил явуулахыг хэлнэ” хэмээн тодорхойлсон байна.

Гадаад, дотоод орчны өөрчлөлт болон байгууллагын хөгжлийн хандлагаас хамааран хүний нөөцийн удирдлагын тодорхой асуудлаар өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс үүсэж болох үр дагаврыг тооцон, шаардлагатай үед эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлнэ.

Удирдлагаар хангах бодлогод мэргэшсэн чадавхтай албан хаагчдыг хадгалах, албан хаагчдад хөрвөх, сэлгэх, хавсарч ажиллах чадавх бий болгох, байгууллагын зохион байгуулалтын болон бүтцийн өөрчлөлтөд бэлэн байх, ажилтнуудыг давхар мэргэжил, мэргэшил эзэмшүүлэх, албан хаагчдыг байршуулах, нөөцийг шийдвэрлэх талаар тусгасан байна.

Хариуцлага хүлээх чадвартай, албан тушаал дэвших боломжтой, мэдлэг, дадлага, туршлага бүхий ажилтныг зорилтод сургалтад хамруулж, шаардлагатай ажлын байранд байршуулах, сэлгэх карьер хөгжлийн тогтолцоог бий болгоно. Удирдах ажилтанд манлайлал, ёс зүйн өндөр шаардлага тавьж, эрх мэдэл, хариуцлагын тогтолцоог тэнцвэржүүлнэ.

Онцгой байдлын удирдлага гэдэг нь онцгой байдлын бүх асуудлаар, тухайлбал бэлэн байдал, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр нөөц, үүрэг хариуцлагыг зохион байгуулах, удирдахыг хэлнэ.¹ Өөрөөр хэлбэл нэн тэргүүнд гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, гамшиг тохиолдсон үед эрэн хайх, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг аль болох үр дүнтэй болоход чиглэгдсэн өргөн хүрээтэй, хөгжлийн чиг хандлагатай цогц үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, гамшгийн үе шатанд авч хэрэгжүүлэх үндсэн бодлого, засаг захиргааны шийдвэр шуурхай ажиллагаа гэж үзэж болно.

Онцгой байдлын байгууллагын удирдлагын түвшнийг стратеги удирдлага, оператив удирдлага, тактикийн удирдлага гэж гурав ангилан гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах стратегийн удирдлагын түвшинд: Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Засгийн газар, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Яам, Улсын албад ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурал нь Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг тодорхойлж, Гамшгаас хамгаалах тухай хуулийг баталж байна.

¹ ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэн, Гамшгийн нэр томъёоны тайлбар толь, УБ. 2012, 14 дэх тал

Монгол Улсын Засгийн газар нь гамшгаас хамгаалах асуудлаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үндэсний төсөл, хөтөлбөрийг батлах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшгийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, гамшгийн зэрэглэл тогтоох журмыг батлах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг оролцуулах шийдвэрийг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах, олон улсын эрэн хайх, аврах ажиллагаанд аврах багийг оролцуулах шийдвэр гаргах, аюулын түвшин, нөхцөл байдлын талаар нийтэд зарлан мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Монгол Улсын хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл байгуулагдан Ерөнхий сайдын удирдлагад ажиллана.

Үндэсний болон орон нутгийн зөвлөл нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэгтэй бөгөөд орон тооны бус байна.

Улсын онцгой комиссыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шадар сайд тэргүүлдэг. Харин гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, шадар сайд нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан чиглүүлэх, улсын хэмжээнд, эсхүл аймаг, нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт үүссэн буюу үүсч болзошгүй гамшгийн үед өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлнэ.

Мөн гамшгийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад шуурхай мэдээлэх, гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн байгууллагын зарим анги, салбарыг татан оролцуулах саналыг Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх, онцгой байдлын байгууллагыг хөгжүүлэх бодлого болон түүний үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан Засгийн газарт танилцуулах, шийдвэрлүүлэх зэрэг эрхийг хэрэгжүүлнэ.

Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн.¹

¹ Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2017, хуулийн 42.1 дэх заалт

Онцгой байдлын алба гэдэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг улс орны хэмжээнд зохион байгуулах үндсэн үүрэгтэй алба юм.

Онцгой байдлын байгууллага нь улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулна.¹

Гамшгаас хамгаалах оперативын удирдлагын түвшинд Онцгой байдлын бүсийн төв, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг болон бусад нэгж ажиллана. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хяналт тавих зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус албыг аймаг, нийслэл, дүүрэгт, орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.²

Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг баталж, гүйцэтгэлд хяналт тавих, гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох, тайланг хэлэлцэх, чиглэл өгөх, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэх сан байгуулах шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, удирдах, хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг байгуулах, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох, гамшиг болон аюулын үед шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулна.

Гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны болон онцгой байдлын байгууллагад мэдээлэх, мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгаа, дэмжлэг авах, хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, нэрвэгдэгсдэд санхүүгийн болон эд материал, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд иргэдийн оролцоог хангана.

¹ Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2017, хуулийн 22.4 дэх заалт

² Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2017, хуулийн 22.6 дахь заалт

Түүнчлэн гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, гамшиг болон аюулын үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүч хэрэгслийг татан оролцуулах, орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэх, харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах, гамшгийн эрсдэлийн болон гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэж, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах тактикийн удирдлагын түвшинд гамшигтай тэмцэх асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлдэг. Ингэхдээ сум, баг, хороонд нутгийн иргэдэд түшиглэн гамшгаас хамгаалах сайн дурын хэсгийг байгуулж ашиглана. Сум, дүүрэг, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангитай байна.¹

Дээрх 3 удирдлагын түвшингээс гамшгаас хамгаалах оперативын удирдлагын түвшинд хамаарах онцгой байдлын бүсийн төв, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг болон бусад нэгж ажиллах үеийн удирдах албан тушаалтны манлайлалд дүн шинжилгээ хийлээ.


Манлайлал, манлайллын арга барил, хувь хүний ур чадварыг судлан үзэхдээ төлөөлөх чадварыг тооцон, Онцгой байдлын байгууллагын алба хаагчдаас түүврийн бүлгийн сонгон судалгааг явуулсан болно .

Судалгаанд нийт 210 оролцогч хамрагдсан хүчин төгөлдөр оролцогчийн өгөгдөлд боловсруулалт хийн асуумж бүрээр тоймлон ерөнхий мэдээлэл гаргасан. Үүнд:

¹ Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2017, хуулийн 22.8 дэх заалт

⁴⁴ Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ., 2017, хуулийн 24.1 дэх заалт

Зураг 2. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн



Тайлбар: work experience-ажлын туршлага,
specialization skills-мэргэшсэн байдал үр чадвар,
The performance-ажлын гүйцэтгэл, work
participation-ажлын оролцоо, LEAD-манлайлал.

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Ажлын туршлага	Wo2exp-1	0.794	0.918	0.964	0.841
	Wo2exp-2	0.922			
	Wo2exp-3	0.890			
	Wo2exp-4	0.894			
	Wo2exp-5	0.850			

Хүснэгт 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Тайлбар Wo2exp-1 Таны ажлын туршлагыг удирдлага бодит үнэлдэг байдал нь 0.794 буюу үр дүнг илэрхийллээ.

Wo2exp-2 Удирдлага өөрийн мэргэжлийн туршлагаа түгээх байдал нь 0.862 буюу үр дүнг илэрхийллээ.

Wo2exp-3 Удирдах ажилтны хуримтлуулсан туршлага нь 0.919 буюу үр дүнг илэрхийллээ.

Wo2exp-4 Удирдлагын зүгээс туршлага солилцох байдал нь 0.935 буюу үр дүнг илэрхийллээ.

Wo2exp-5 Таны удирдах ажилтны туршлага одоогийн албан тушаалдаа нийцэх байдал нь 0.862 буюу үр дүнг илэрхийллээ. Судалгааны ажлын нэг хувьсагч болох хувь хүний хүчин зүйлийн нөлөөлөл болох алба хаагчдын ур чадварын есөн асуулт болох далд хувьсагчаар судаллаа.

Ажлын туршлагын далд хувьсагчид 0.794-0.922 хооронд хэлбэлзсэн. Удирдлагын зүгээс туршлага солилцох байдал ба Wo2exp-2 кодлол бүхий далд хувьсагч 0.922 хамгийн өндөр сайн үр дүнг илэрхийллээ. Таны ажлын туршлагыг удирдлага бодит үнэлдэг байдлын үр дүн бусад дөрвөн далд хувьсагчаас бага буюу 0.794 үр дүнтэй утга гарсан. Алба хаагчдын ажлын туршлагын Кронбах альфа утга 0.918 гарсан нь хамгийн сайн байгааг илэрхийлнэ.

Хүснэгт 2. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Мэргэшсэн байдал ур чадвар	Skills-1	0.816	0.938	0.963	0.838
	Skills-2	0.939			
	Skills-3	0.912			
	Skills-4	0.901			
	Skills-5	0.906			

Тайлбар:

Skills-1 Удирдах албан тушаалтны нарийн мэргэшсэн байдал нь 0.816 буюу үр дүнг илэрхийллээ

Skills-2 Шийдвэр гаргах ур чадварын мэргэшсэн байдал нь 0.939 буюу үр дүнг илэрхийллээ.

Skills-3 Хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд анхаарах байдал нь 0.912 буюу үр дүнг илэрхийллээ

Skills-4 Багаар ажиллах чадварт мэргэшсэн байдал нь 0.901 буюу үр дүнг илэрхийллээ

Skills-5 Удирдах ажилтны бүтээлч сэтгэлгээ эзэмшсэн байдал нь 0.906 буюу үр дүнг илэрхийллээ. Судалгааны ажлын нэг хувьсагч болох манлайллын хүчин зүйлийн нөлөөлөл болох удирдах алба хаагчдын Мэргэшсэн байдал ур чадвар таван асуулт болох далд хувьсагчаар судаллаа.

Алба хаагчдын Мэргэшсэн байдал ур чадварын далд хувьсагчид 0.739-0.935 хооронд хэлбэлзсэн. Багаар ажиллах чадварт мэргэшсэн байдал ба skl-4 кодлол бүхий далд хувьсагч 0.939 хамгийн өндөр сайн үр дүнг илэрхийллээ. Удирдах албан тушаалтны нарийн мэргэшсэн байдлын үр дүн бусад дөрвөн далд хувьсагчаас бага буюу 0.816 үр дүнтэй утга гарсан. Алба хаагчдын ур чадварын Кронбах альфа утга 0.938 гарсан нь хамгийн сайн байгааг илэрхийлнэ

Хүснэгт 3. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Ажлын гүйцэтгэл	Wo2per-1	0.868	0.953	0.939	0.755
	Wo2per-2	0.893			
	Wo2per-3	0.940			
	Wo2per-4	0.893			
	Wo2per-5	0.850			

Тайлбар:

Wo2per-1 Ажлын арга барил нь таны ажлын гүйцэтгэлд нөлөөлөх байдал нь 0.868 буюу үр дүнг илэрхийллээ

Wo2per-2 Удирдах ажилтны ажилдаа зарцуулж буй цагийн төлөвлөлт нь 0.893 буюу үр дүнг илэрхийллээ.

Wo2per-3 Удирдах ажилтны ажил гүйцэтгэхдээ зөвлөгөө өгөх байдал нь 0.940 буюу үр дүнг илэрхийллээ

Wo2per-4 Ажлын гүйцэтгэлийн дүгнэлт гаргах ур чадвар байдал нь 0.893 буюу үр дүнг илэрхийллээ

Wo2per-5 Гүйцэтгэлийг хэмжих бодит байдал нь 0.850 буюу үр дүнг илэрхийллээ. Судалгааны ажлын нэг хувьсагч болох хувь хүний хүчин зүйлийн нөлөөлөл болох алба хаагчдын ур чадварын есөн асуулт болох далд хувьсагчаар судаллаа.

Алба хаагчдын ажлын гүйцэтгэлийн далд хувьсагчид 0.850-0.940 хооронд хэлбэлзсэн. Удирдах ажилтны ажил гүйцэтгэхдээ зөвлөгөө өгөх байдал ба Wo2per-3 кодлол бүхий далд хувьсагч 0.940 хамгийн өндөр сайн үр дүнг илэрхийллээ. Гүйцэтгэлийг хэмжих бодит байдлын үр дүн бусад дөрвөн далд хувьсагчаас бага буюу 0.850 үр дүнтэй утга гарсан. Алба хаагчдын ажлын гүйцэтгэлийн Кронбах альфа утга 0.953 гарсан нь хамгийн сайн байгааг илэрхийлнэ

Хүснэгт 4. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Ажлын оролцоо	Wo2enga-1	0.846	0.951	0.983	0.856
	Wo2enga-2	0.907			
	Wo2enga-3	0.926			
	Wo2enga-4	0.960			
	Wo2enga-5	0.934			

Тайлбар: Wo2enga-1 Баг хамт олны уур амьсгалыг эерэг болгоход оролцох байдал нь 0.846 буюу үр дүнг илэрхийллээ

Wo2enga-2 Ажилтнуудад зөвлөгөө өгдөг байдал нь 0.907 буюу үр дүнг илэрхийллээ.

Wo2enga-3 Алба хаагчдын саналыг анхаарч сонсдог, дэмждэг байдал нь 0.926 буюу үр дүнг илэрхийллээ

Wo2enga-4 Шийдвэр гаргахдаа таны оролцоог дэмждэг байдал нь 0.960 буюу үр дүнг илэрхийллээ

Wo2enga-5 Танай багийн оролцоог хүлээн зөвшөөрдөг байдал нь 0.934 буюу үр дүнг илэрхийллээ. Судалгааны ажлын нэг хувьсагч болох хувь хүний хүчин зүйлийн нөлөөлөл болох алба хаагчдын ур чадварын есөн асуулт болох далд хувьсагчаар судаллаа.

Алба хаагчдын ажлын оролцооны далд хувьсагчид 0.846-0.960 хооронд хэлбэлзсэн. Шийдвэр гаргахдаа таны оролцоог дэмждэг байдал ба Wo2enga-4 кодлол бүхий далд хувьсагч 0.960 хамгийн өндөр сайн үр дүнг илэрхийллээ. Баг хамт олны уур амьсгалыг эерэг болгоход оролцох байдлын үр дүн бусад дөрвөн далд хувьсагчаас бага буюу 0.846 үр дүнтэй утга гарсан. Алба хаагчдын ажлын оролцооны Кронбах альфа утга 0.951 гарсан нь хамгийн сайн байгааг илэрхийлнэ.

Хүснэгт 5. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Манлайлал	Leadership-1	0.901	0.981	0.953	0.802
	Leadership-2	0.938			
	Leadership-3	0.916			
	Leadership-4	0.894			
	Leadership-5	0.931			
	Leadership-6	0.955			
	Leadership-7	0.939			
	Leadership-8	0.921			
	Leadership-9	0.938			

Тайлбар: lead-1 Хамт олноо удирдан зохион байгуулж чаддаг байдал нь 0.901 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-2 Ажлаа оновчтой төлөвлөж чаддаг эсэх нь 0.938 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-3 Шийдвэрийг оновчтой гаргаж чаддаг эсэх нь 0.916 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-4 Бусдад боломж олгож чаддаг эсэх нь 0.894 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-5 Мэдлэгээрээ бусдад хүлээн зөвшөөрөгдөж чаддаг эсэх нь 0.931 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-6 Ур чадвараараа бусдад хүлээн зөвшөөрөгдөж чаддаг эсэх нь 0.955 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-7 Хандлагаараа бусдад хүлээн зөвшөөрөгдөж чаддаг эсэх нь 0.939 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-8 Бусдад нөлөөлөх байдал нь 0.739 буюу үр дүнг илэрхийллээ.

lead-9 Бусдад ажлын арга барилаараа үлгэрлэх байдал нь 0.796 буюу үр дүнг илэрхийллээ.

Судалгааны ажлын нэг хувьсагч болох хувь хүний хүчин зүйлийн нөлөөлөл болох алба хаагчдын ур чадварын есөн асуулт болох далд хувьсагчаар судаллаа.

Алба хаагчдын манлайллын далд хувьсагчид 0.739-0.935 хооронд хэлбэлзсэн. Ур чадвараараа бусдад хүлээн зөвшөөрөгдөж чаддаг эсэх lead-6 кодлол бүхий далд хувьсагч 0.955 хамгийн өндөр сайн үр дүнг илэрхийллээ. Бусдад боломж олгож чаддаг эсэх чадварын үр дүн бусад найман далд хувьсагчаас бага буюу 0.894 үр дүнтэй утга гарсан. Алба хаагчдын манлайллын Кронбах альфа утга 0.981 гарсан нь хамгийн сайн байгааг илэрхийлнэ

Судалгааны ажлын хүчин зүйлийн шинжилгээнээс харахад:

Ажлын туршлага ба манлайллын 5 далд хувьсагч 0.794-0.850 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.918, найдвартай байдлын утга 0.964, дундаж утга 0.841 байгаа нь найдвартай байдал, дундаж утга 0.366 байна.

Мэргэшсэн байдал ба ур чадварын 5 далд хувьсагч 0.816-0.906 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.938, найдвартай байдлын утга 0.963, дундаж утга 0.838 батлагдаагүй байна.

Ажлын гүйцэтгэл ба манлайллын 5 далд хувьсагч 0.868-0.850 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.953, найдвартай байдлын утга 0.939, дундаж утга 0.755 байна.

Ажлын оролцоо ба манлайллын 5 далд хувьсагч 0.846-0.934 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.951, найдвартай байдлын утга 0.983, дундаж утга 0.856 байна.

ДҮГНЭЛТ

Онцгой байдлын байгууллагын удирдлага гэдэг нь нэн тэргүүнд гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, гамшиг тохиолдсон үед эрэн хайх, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг аль болох үр дүнтэй болоход чиглэгдсэн цогц үйл ажиллагаа юм.

Дээрх үйл ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах удирдлагыг хэрэгжүүлэхдээ стратеги, оператив, тактикийн гэсэн 3 түвшинд авч үздэг.

Дээрх 3 удирдлагын түвшингээс оперативын удирдлагын түвшинд хамаарах онцгой байдлын бүсийн төв, төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг болон бусад нэгж ажиллах үеийн удирдах албан тушаалтны манлайлалд дүн шинжилгээ хийлээ.

Онцгой байдлын байгууллагын удирдах албан тушаалтны анлайллын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээг хийхдээ Онцгой байдлын байгууллагын алба хаагчдаас түүврийн бүлгийн сонгон судалгаанд нийт 210 оролцогч хамруулан SMART PLS 3.0 болон Онцгой байдлын байгууллагын тал бүрээс нь бүрэн бодитой судлан тогтооход асуулгын аргаар 103 алба хаагчаас судалгаа аван SPSS 24.0 аргаар боловсруулалтыг хийн, судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг гаргасан.

Манлайлал, манлайллын арга барил, мэдлэг, хувь хүний ур чадварын хүчин зүйл хэрхэн хамаарах хамаарлыг судалгаагаар таамаглал дэвшүүлсэн. Судалгаанд оролцогчдод өгөгдөлд боловсруулалт хийн шинжлэн, SMART PLS-3.0, SPSS-25.0 программ хангамжийг ашиглаж, хэмжил зүй, хүчин зүйл, замын шинжилгээг хийж, судалгааг манлайллын онолд суурилан, ажлын гүйцэтгэл, мэргэшсэн байдал ба ур чадвар, ажлын гүйцэтгэл, ажлын оролцоо, ажлын туршлага гэсэн хувьсагчдыг таамаглал болгон дэвшүүлж судалсан. Хүчин зүйлийн шинжилгээгээр далд хувьсагч бүрийн уялдаа холбоо, хамаарлыг нарийн шинжилсэн. Дэвшүүлсэн 4-н таамаглалаас мэргэшсэн байдал ба ур чадвар, ажлын туршлага гэсэн хувьсагч батлагдсан, ажлын гүйцэтгэл, ажлын оролцоо гэсэн таамаглал батлагдсангүй. Ажлын гүйцэтгэл, манлайлалд нөлөөлөх нь асуумжид оролцогчид үнэлгээг бага үнэлсэн ба өөртөө анхаарал хандуулах байдлыг бусад асуумжаас доогуур үнэлсэн нь анхаарах асуудал болж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. **Монгол Улсын** Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/, УБ., 2017
2. Д.Сэржмядаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, УБ., 2017
3. Burns, J.Me., Leadership., New-Work., 1978
4. Бернард М Басс., Роналд.Е.Рижжо., Манлайллын гарын авлага., 1990.
5. Монгол хэлний их тайлбар толь бичиг. Уб., 2015.
6. В.Удвал “Удирдлагын эрх зүй. Уб., 2000. 38 дахь тал
7. ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэн, Гамшгийн нэр томъёоны тайлбар толь, Уб. 2012, 14 дэх тал